

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2006 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

“Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах,
түүнд хяналт тавих журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Даатгалын компанийн даатгалын хэлбэр тус бүрийн гарч болзошгүй хохирлын нөөцийн сангийн эхний үлдэгдлийг 2006 оны 2 дугаар улирлын нөөцийн сангийн эцсийн үлдэгдлээр тооцсугай.
3. Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мониторинг, судалгааны газар /А. Тамир/-т даалгасугай.
4. Энэхүү журмыг 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ШАРАВСАМБУУ

ДААТГАЛЫН НӨӨЦИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т "даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих журам" заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2. Энэхүү журам нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагчид хамаарна.

ХОЁР. ДААТГАЛЫН НӨӨЦИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ

- 2.1. Даатгагч дараах нөөцийн сангуудыг даатгалын хэлбэр тус бүрээр байгуулна */Энэ хэсгийг Хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн дугаар 17 тогтоолоор өөрчлөн найруулсан/*:
 - 2.1.1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц;
 - 2.1.2. Нэхэмжилсэн хохирлын нөөц;
 - 2.1.3. Учирч болзошгүй хохирлын нөөц.
- 2.2. Даатгалын нийт хураамжийн орлогоос давхар даатгалын хураамж, буцаасан даатгалын хураамжийг хасч даатгалын цэвэр хураамжийг тодорхойлно.
- 2.3. Давхар даатгалын хураамжийг даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дотоод, гадаадын өөр даатгагчид дахин даатгаж төлсөн төлбөрөөр тодорхойлогдоно.
- 2.4. Буцаасан даатгалын хураамжийг хууль тогтоомжийн дагуу даатгалын гэрээнээс өмнө даатгагч даатгуулагчид тухайн гэрээний үлдэх хугацаанд ногдуулан буцаан олгосон хураамжаар тодорхойлогдоно.
- 2.5. Орлогод тооцсон хураамжийн орлого гэж даатгалын цэвэр хураамжийн орлогоос тайлант хугацаанд ногдох хураамжийг орлогод тооцон авсан дүнгээр тодорхойлно.
- 2.6. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжийг гэрээний үлдэх хугацаанд ногдуулан байгуулна. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн сан нь даатгалын цэвэр хураамжийн орлогоос орлогод тооцсон хураамжийг хассан дүнтэй тэнцүү байна.
- 2.7. Орлогод тооцсон хураамжийг тухайн улирлын даатгалын цэвэр хураамжийн орлогоос дараах харьцаагаар тооцно:

1 дэх улиралд	1/8
2 дахь улиралд	3/8
3 дахь улиралд	5/8
4 дэх улиралд	7/8

- 2.8. Нэхэмжилсэн хохирлын нөөцийн санг тухайн тайлант хугацаанд даатгуулагчаас ирүүлсэн нэхэмжлэлийн дүнгээр байгуулна.
- 2.9. Учирч болзошгүй хохирлын нөөцийн санг тухайн тайлант хугацаанд хохирол гараагүй боловч гарч болзошгүй хохирлыг барагдуулахад зориулан байгуулна.
- 2.10. Даатгалын хэлбэр тус бүрийн учирч болзошгүй хохирлын нөөцийн санг орлогод тооцсон хураамжаас тухайн тайлант хугацааны нэхэмжилсэн хохирол, болон даатгалын цэвэр нөхөн олговрыг хассан дүнгээс дор дурьдсан хувиар тооцон байгуулна */Энэ хэсэгт Хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн дугаар 17 тогтоолоор өөрчлөлт оруулсан/*:
- | | |
|-------------------------------|-----|
| 2.10.1. Жолоочийн хариуцлагын | 50% |
| 2.10.2. Тээврийн хэрэгслийн | 40% |
| 2.10.3. бусад | 15% |
- 2.11. Нийт нөхөн олговрын дүнгээс давхар даатгалаас авсан нөхөн олговрын дүнг хассан дүнгээр даатгалын цэвэр нөхөн олговрыг тодорхойлно.
- 2.12. Давхар даатгалаас авсан нөхөн олговрыг даатгалын тохиолдол болоход давхар даатгалын гэрээний авах нөхөн төлбөрөөр тодорхойлогдоно.

ГУРАВ. ДААТГАЛЫН НӨӨЦИЙН САНГ ЗАРЦУУЛАХ

- 3.1. Орлогод тооцсон хураамжийн орлогоос тухайн тайлант хугацаанд гарсан хохирлыг барагдуулна.
- 3.2. Орлогод тооцсон хураамж нь даатгалын хохирлыг төлөхөд хүрэлцэхгүй болсон тохиолдолд учирч болзошгүй хохирлын нөөцийн сангаас нөхөн олговрыг олгоно.
- 3.3. Учирч болзошгүй хохирлын нөөцийн сан хохирол нөхөлтөд хүрэлцэхгүй болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд дүрмийн сангаас олгохоос 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН НӨӨЦИЙН САНД ТАВИХ ХЯНАЛТ

- 4.1. Даатгалын нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд Санхүүгийн зохицуулах хороо улирал тутам хяналт тавина.
- 4.2. Даатгалын нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан маягтуудын дагуу гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд улирал бүр ирүүлнэ.

--ooOo--